

Улирлын урьдчилсан төлөв

НЭГ. ТАНЫ АНХААРАЛД

Ус, Цаг Уур, Орчны Судалгаа Мэдээллийн Хүрээлэн (УЦУОСМХ)-ийн Цаг агаар орчны тоон загварчлал судалгааны хэлтэс (ЦАОТЗСХ)-ээс 2024 оны 5 дугаар сараас 7 дугаар саруудын урьдчилсан төлөвийг тооцоолон танд хүргэж байна.

Урьдчилсан төлөвийг <http://www.tsag-agaar.mn/> цахим хуудсанд сар бүрийн 28-нд шинэчлэн гаргадаг тул хэрэглэгч та бүхэн тухай бүрд нь шинэчилсэн мэдээг ашиглаж байна уу.

Дэлхийн Цаг уурын байгууллагаас тогтоосноор олон жилийн дундаж (ОЖД) утга гэдэгт 1991-2020 оны хоорондох тухайн цаг уурын хэмжигдэхүүний дундаж утгыг авч үздэг.

Улирлын төлөвийн талаар лавлах шаардлагатай бол УЦУОСМХ-ийн 11-326606 утсаар холбогдох болон тус хүрээлэнгийн ЦАОТЗСХ-ээс тодруулах боломжтой.

ХОЁР. УУР АМЬСГАЛЫН ТОЙМ

2.1 5–7 дугаар саруудын уур амьсгал



Агаарын температур 5 дугаар сард Баян–Өлгий, Завхан, Хөвсгөл, Архангайн ихэнх нутаг, Говь–Алтай, Баянхонгор, Өвөрхангайн хойд болон Төвийн зүүн хойд хэсгээр 2...8°C, Алтайн өвөр говь болон говийн бүс нутгаар 15...19°C, бусад нутгаар 10...15°C дулаан байдаг байна. 6 дугаар сард Баян–Өлгийн ихэнх нутаг, Увс, Архангайн баруун, Завханы зүүн, Баянхонгор, Хөвсгөлийн хойд хэсгээр 6...10°C, Өмнөговь, Дорноговийн ихэнх нутаг, Говь–Алтай, Баянхонгор, Дундговийн өмнөд хэсгээр 20...24°C, бусад нутгаар 12...18°C дулаан байдаг байна. Харин 7 дугаар сард Баян–Өлгийн нутаг, Увсын баруун, Ховдын төв хэсэг, Завханы зүүн өмнөд, Баянхонгорын хойд, Хөвсгөлийн ихэнх, Архангайн баруун өмнөд, Төвийн зүүн хойд хэсгээр 8...14°C, Говь–Алтай, Баянхонгор, Өвөрхангай, Дундговийн өмнөд, Өмнөговь, Дорноговийн нутаг, Сүхбаатарын баруун өмнөд болон Дорнодын ихэнх нутгаар 20...26°C, бусад нутгаар 14...20°C дулаан байдаг байна.

Хур тунадасны хувьд 5 дугаар сард Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулархаг нутгаар 21–30 мм, Их нууруудын хотгор, Алтайн өвөр говь, болон говийн бүс нутгаар 0–10 мм, бусад нутгаар 11–20 мм ордог бол 6 дугаар сард Хөвсгөл, Хэнтийн уулархаг нутгаар 60–70 мм, Их Нуруудын Хотгор, Алтайн өвөр говь болон говийн бүс нутгаар 10–20 мм, бусад нутгаар 20–60 мм хүртэл хур тунадас ордог байна. Харин 7 дугаар сард Хөвсгөл, Архангай, Булган, Сэлэнгэ, Дорнодын нутаг, Төвийн зүүн хойд, Хэнтийн хойд, Дорнодын зүүн хэсгээр 70–100 мм, Баян–Өлгий, Ховд, Говь–Алтай, Баянхонгор, Өмнөговь, Дорноговийн нутаг, Өвөрхангай, Дундговийн өмнөд хэсгээр 0–40 мм, бусад нутгаар 40–70 мм бороо ордог байна



ГУРАВ. 2024 ОНЫ 5–7 ДУГААР САРУУДЫН УРЬДЧИЛСАН ТӨЛӨВ

3.1 2024 оны 5–7 дугаар саруудын цаг агаарын урьдчилсан төлөв

Тавдугаар сард. Сарын дундаж агаарын температур ОЖД–аар Баян–Өлгий, Завхан, Хөвсгөл, Архангайн ихэнх нутаг, Говь–Алтай, Баянхонгор, Өвөрхангайн хойд болон Төвийн зүүн хойд хэсгээр 2...8°C, Алтайн өвөр говь болон говийн бүс нутгаар 15...19°C, бусад нутгаар 10...15°C дулаан байдаг байна (**Зураг 1а**). 2024 оны 5 дугаар сарын агаарын дундаж температур нутгийн баруун хагаст (Тухайлбал: Баян–Өлгий, Увс, Ховд, Завхан, Говь–Алтай, Баянхонгорын нутаг, Хөвсгөлийн ихэнх, Архангай, Өвөрхангай, Өмнөговийн баруун хэсгээр) ОЖД–аас дулаан, бусад нутгаар дунджийн орчим байх төлөвтэй байна (**Зураг 1б**).




Зураг 1а. 5 дугаар сарын агаарын температурын ОЖД (1991-2020)




Зураг 16. 2024 оны 5 дугаар сарын агаарын температурын урьдчилсан төлөв (°C)

[Д-агаарын температур ОЖД-аас дулаан, Н-агаарын температур ОЖД-ын орчим]

Сарын нийлбэр хур тунадас ОЖД–аар Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулархаг нутгаар 21–30 мм, Их нууруудын хотгор, Алтайн өвөр говь, болон говийн бүс нутгаар 0–10 мм, бусад нутгаар 11–20 мм ордог байна (**Зураг 2а**). 2024 оны 5 дугаар сарын нийлбэр хур тунадас Баян–Өлгий, Увс, Ховд, Говь–Алтайн нутаг, Завхан, Өмнөговийн баруун, Баянхонгорын өмнөд хэсгээр ОЖД–аас бага, Хөвсгөлийн зүүн, Булган, Сэлэнгийн нутаг, Төв, Хэнтий, Дорнодын хойд хэсгээр ОЖД–аас ахиу, бусад нутгаар дунджийн орчим орох төлөвтэй байна (**Зураг 2б**).









Зураг 26. 2024 оны 5 дугаар сарын хур тунадасны урьдчилсан төлөв (мм)

[Б–хур тунадас ОЖД–аас бага, Н–хур тунадас ОЖД–ийн орчим, И–хур тунадас ОЖД–аас ахиу]

Зургаадугаар сард. Сарын дундаж агаарын температур ОЖД–аар Баян–Өлгийн ихэнх нутаг, Увс, Архангайн баруун, Завханы зүүн, Баянхонгор, Хөвсгөлийн хойд хэсгээр +6...+10°C, Өмнөговь, Дорноговийн ихэнх нутаг, Говь–Алтай, Баянхонгор, Дундговийн өмнөд хэсгээр +20...+24°C, бусад нутгаар +12...+18°C дулаан байдаг байна. **(Зураг 3а).** 2024 оны 6 дугаар сарын агаарын дундаж температур Баян–Өлгий, Ховдын нутаг, Увс, Говь–Алтайн ихэнх, Завханы баруун, Баянхонгор өмнөд хэсгээр ОЖД–аас дулаан, бусад нутгаар дунджийн орчим байх төлөвтэй байна **(Зураг 3б).**




Зураг 3а. 6 дугаар сарын агаарын температурын ОЖД (1991-2020)




Зураг 3б. 2024 оны 6 дугаар сарын агаарын температурын урьдчилсан төлөв (°C)

[Д-агаарын температур ОЖД-аас дулаан, Н-агаарын температур ОЖД-ын орчим]

Сарын нийлбэр хур тунадас ОЖД-аар Хөвсгөл, Хэнтийн уулархаг нутгаар 60–70 мм, Их Нуруудын Хотгор, Алтайн өвөр говь болон говийн бүс нутгаар 10–20 мм, бусад нутгаар 20–60 мм хүртэл хур тунадас ордог байна (**Зураг 4а**). 2024 оны 6 дугаар сарын нийлбэр хур тунадас Төвийн ихэнх, Сэлэнгийн зүүн, Дундговь, Дорноговийн хойд хэсэг болон Хэнтий, Дорнод, Сүхбаатарын нутгаар ОЖД-аас ахиу, бусад нутгаар дунджийн орчим байх төлөвтэй байна (**Зураг 4б**).





Зураг 4а. 6 дугаар сарын хур тунадасны ОЖД (1991-2020)





Зураг 46. 2024 оны 6 дугаар сарын хур тунадасны урьдчилсан төлөв (мм)

[Н-хур тунадас ОЖД-ийн орчим, И-хур тунадас ОЖД-аас ахиу]

Долдугаар сард. Сарын дундаж агаарын температур ОЖД-аар Баян-Өлгийн нутаг, Увсын баруун, Ховдын төв хэсэг, Завханы зүүн өмнөд, Баянхонгорын хойд, Хөвсгөлийн ихэнх, Архангайн баруун өмнөд, Төвийн зүүн хойд хэсгээр 8...14°C, Говь-Алтай, Баянхонгор, Өвөрхангай, Дундговийн өмнөд, Өмнөговь, Дорноговийн нутаг, Сүхбаатарын баруун өмнөд болон Дорнодын ихэнх нутгаар 20...26°C, бусад нутгаар 14...20°C дулаан байдаг (**Зураг 5а**). 2024 оны 7 дугаар сарын агаарын дундаж температур Завханы зүүн, Баянхонгор, Өвөрхангайн хойд, Хөвсгөл, Архангай, Булган, Сэлэнгэ, Төв, Хэнтий, Дорнодын нутаг, Сүхбаатарын ихэнх хэсгээр ОЖД-аас хүйтэн, бусад нутгаар дунджийн орчим байх төлөвтэй байна (**Зураг 5б**).




Зураг 5а. 7 дугаар сарын агаарын температурын ОЖД (1991-2020)




Зураг 5б. 2024 оны 7 дугаар сарын агаарын температурын урьдчилсан төлөв (°C)
[X-агаарын температур ОЖД-аас хүйтэн, H-агаарын температур ОЖД-ын орчим]

Сарын нийлбэр хур тунадас ОЖД-аар Хөвсгөл, Архангай, Булган, Сэлэнгэ, Дорнодын нутаг, Төвийн зүүн хойд, Хэнтийн хойд, Дорнодын зүүн хэсгээр 70–100 мм, Баян-Өлгий, Ховд, Говь-Алтай, Баянхонгор, Өмнөговь, Дорноговийн нутаг, Өвөрхангай, Дундговийн өмнөд хэсгээр 0–40 мм, бусад нутгаар 40–70 мм бороо ордог байна (**Зураг 6а**). 2024 оны 7 дугаар сарын нийлбэр хур тунадас Завханы зүүн, Өвөрхангай, Сүхбаатарын хойд, Хөвсгөл, Архангай, Булган, Сэлэнгэ, Төв, Хэнтий, Дорнодын нутагаар ОЖД-аас ахиу, бусад нутгаар дунджийн орчим байх төлөвтэй байна (**Зураг 6б**).



Зураг 6а. 7 дугаар сарын хур тунадасны ОЖД (1991-2020)



**Зураг 6б. 2024 оны 7 дугаар сарын хур тунадасны урьдчилсан төлөв (мм)
[Н-хур тунадас ОЖД-ийн орчим, И-хур тунадас ОЖД-аас ахиу]**

3.2 Зөвлөмж

Агаарын дундаж температур: 5 дугаар сард нутгийн баруун хагаст, 6 дугаар сард баруун аймгуудын ихэнх нутгаар ОЖД-аас дулаан, 7 дугаар сард нутгийн хойд хэсгээр ОЖД-аас хүйтэн, бусад нутгаар дунджийн орчим байх төлөвтэй байна.

Хур тунадас: 5 дугаар сард баруун аймгуудын нутгаар дунджаас бага, нутгийн зүүн хойд хэсгээр дунджаас ахиу, 6 дугаар сард төвийн аймгуудын нутгийн зүүн хэсэг, зүүн аймгуудын нутгаар, 7 сард төв болон зүүн аймгуудын нутгаар ОЖД-аас ахиу, бусад хугацаанд болон бусад нутгаар дунджийн орчим байх төлөвтэй байна.

5 болон 6 саруудад баруун аймгуудын нутгаар олон жилийн дунджаас дулаан байх төлөв ажиглагдаж байгаа боловч 7 дугаар сард төв болон зүүн аймгуудын нутгаар дунджаас хүйтэн байх төлөвтэй байна. Хур тунадасны хувьд хаврын сүүл сар болон зуны саруудад төв болон зүүн аймгуудын нутгаар олон жилийн дунджаас ахиу хур тунадас орох төлөвтэй байна.